





Оксфордын  
уншлагын  
мод




# Динозавруудын өлгий



Родерик Хант  
Алекс Бричта





- Бид шидэт аялал хийж байна  
гэж Чипийг хэлэхэд хүүхдүүд шидэт  
байшингийн хаалгаар гарцгаалаа
- Туслаарай! гэж Надим хашгирав.



Ид шид тэднийг динозавруудын өлгий нутагт авчирчээ.

- Энэ аялал надад таалагдахгүй байна.  
Би динозаврудтай дайралдахаас айж байна гэж Надим хэллээ.



Дээгүүр нь тэмээлзгэнэ нисч байв.  
Хүүхдүүд:  
- Үүнийг хараач! Аварга тэмээлзгэнэ  
байна. Ямар том юм бэ? гэцгээж байлаа.



Чип нэг мөр олжээ. Энэ нь маш том байв.

- Нааш ир үүнийг хараач, энэ л лав динозаврын мөр байх гэв.



Биф тэр аварга мөрний зургийг аваад,  
- Би энэ зургийг сургууль уруугаа авч  
явна аа гэв.



Надим хэдэн өндөг олоод,  
- Ямар том өндөгнүүд вэ? Лав дино-  
заврынх байх гэлээ.




Гэтэл нэг өндөг нь хагарав.

- Эд удахгүй хагарах нь, эндээс юу ч гарч ирж магадгүй гэж Бифийг хэлэхэд, Надим:

- Энэ бол жижигхэн динозавр байна гэв.




Нэгэн том зүйл нисэн ирэхэд хүүхдүүд  
айцгаан,  
- Энэ юу вэ?  
- Мэдэхгүй ээ ...



Хүүхдүүд гүйлдэв.

- Энэ нисдэг динозавр байна. Маш том.

Алив нуугдацгаая гэж Надим хэллээ.



Нисдэг динозавр өндөгнүүд үрүү буун,  
жижиг динозаврыг шүдээрээ зуув.



- Үгүй ээ гэж Биф хашгираад,
- Тэр түүнийг идэх нь байна шүү дээ  
гэж саваа барин түүн үрүү гүйв.
- Холд! гэж хашгирлаа.



Тэр динозавр нисч одсон боловч Чиф  
Бифэд уурлан,

- Чи тэнэг юм уу, тэр чамайг аваад  
явчхаж болох л байлаа гэв.



Вильф атирсан өндөрлөг үрүү гарав.  
Тэр апотозавруудыг харахыг хүсчээ.  
- Биф нааш ир, энд зураг авч болох юм  
байна гэж дуудлаа.



Вильф өндөрлөг дээр гараагүй байжээ.  
Тэр бол атирадсан динозавр байсан ба  
Энормос юм байна. Тэр эргэж Вильфийг  
харав.



Вильф аиж,  
- Өө, туслаарай гэж хашгиран доошоо  
үсрээд,  
- Эндээс явцгаая! гэлээ.



- Битгий ай, энэ бол апотозавр. Үүнийг бид музейд үзсэн шүү дээ. Энэ биднийг яах ч үгүй гэж Чип хэлэв.



Биф зураг авлаа.

- Ямар урт хүзүү, сүүлтэй юм бэ? Надад илүү том аппарат хэрэгтэй юм байна даа гэв.




Апотозавр ус уруу орлоо.

- Ямар том цалгиж байна аа гэж  
Вильфийг хэлэхэд, Надим:
- Өө туслаарай! гэж хашгирлаа.




Өөр бас нэг динозавр ирэхэд тэр  
үнэхээр аймшигтай харагдаж байв.

- Эндээс явцгаая гэж Чип хашгирлаа.



Биф зураг авсаар л байлаа.

- Алив ээ наадахаа боль, биднийг идэх  
нь байна гэж Чип хашгирав.



Тэднийг зугтан гүйхэд Вильфийн  
өрөөсөн гутал нь шаварт шигдчихлээ.  
Энэ үед түлхүүр туяарч эхлэв.  
- Яг цагаа оллоо гэж Чип хэллээ.




Ид шид хүүхдүүдийг Бифийн өрөөнд буцаан авчирлаа.

- Сайхан аялал байлаа, би сайхан зурагнууд авсан гэж Биф баярлав.



- Энэ бол аймшигтай динозавр. Чи үнэхээр үүний зургийг авсан гэж үү? гэж Чипийг асуухад, Биф:
- Тийм ээ. Үүнийгээ ээж аавд үзүүлье гэж хэлэв.



- Би динозаврын зураг авсан гэж  
Бифийг хэлэхэд,
- Өө тийм байна, гэхдээ намайг  
учлаарай би аппаратнаас хальс аваагүй  
л дээ гэж аав хэлэв.





Оксфордын  
уншлагын  
мод

Шатлал 6  
Түүхүүд

# Динозавруудын өлгий



Ид шид дахин эхлэх үед  
хүүхдүүд динозаврын загварууд  
хийж байна.



Хэвлэн нийтлэлийг  
Интерпресс XXX



Дэлхийн банктай хамтран хэрэгжүүлж буй  
«Хөдөөгийн боловсролыг дэмжих  
(READ) төсөлзүйн хүрээнд хэвлэв.  
Худалдахыг хориглоно.